

ГХЯ-НЫ ХӨРШ ОРНУУДЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ Т.БАТЦЭЦЭГИЙН ХЭЛСЭН ҮГ

Олон улс судлалын эрдэм шинжилгээний цуврал хурлыг энэ онд “Монголын Хятад судлал” сэдвээр, нэрт хятад судлаач, академич Чулууны Далайн нэрэмжит болгон зохион байгуулж буйд юуны өмнө Шинжлэх ухааны академийн Олон улсын харилцааны хүрээлэнд талархал илэрхийлье.

Академич Ч.Далай нь шинэ Хятад улс байгуулагдсаны дараагаар тус улсад суралцан төгссөн анхны монгол оюутны нэг байсан бөгөөд Монголын түүх, Монгол-Хятадын харилцааны чиглэлээр эрдэм шинжилгээний олон чухал бүтээл туурвисан нэрт түүхч, эрдэмтэн байсны зэрэгцээ манай улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-нд нийт хоёр удаа ажилласан, нөхцөл байдал амаргүй байх үед хоёр улсын харилцааг хөгжүүлэх үйлсэд гар бие оролцож явсан дипломатч билээ. Тэрээр түүнчлэн Монгол, Хятадын найрамдлын нийгэмлэг 1958 онд байгуулагдахад нарийн бичгийн даргаар нь сонгогдон олон жил нийгэмлэгийн үйл ажиллагаанд голлох үүрэгтэй оролцсоны зэрэгцээ хятад хэлээр гаргадаг “Ажилчны зам” сонины редактораар ажиллах зэргээр хоёр улсын харилцаанд ардын дипломатын шугамаар идэвхтэй оролцож байсан юм. Тиймээс Ч.Далай гуайн ажил үйлсийн амжилт, гавьяаг залуу хойч үедээ сурталчлан таниулах зорилготой энэ удаагийн эрдэм шинжилгээний хурлыг ГХЯ-наас дэмжин, өөрийн байранд зохион байгуулахаар төлөвлөж байсан юм. Дэлхий дахинд томоохон сорилтыг бий болгож буй “Ковид-19” цар тахлын нөхцөл байдлын улмаас өнөөдрийн хурлыг цахим байдлаар зохион байгуулж буй хэдий ч энэ нь хурлын ач холбогдлыг бууруулж чадахгүй гэдгийг тэмдэглэхийг хүсч байна.

Академич Ч.Далай 1998 онд бичсэн дурсамждаа “Монгол, Хятадын ард түмний харилцаа уламжлалтай, сонирхолтой, судлууштай, ирээдүйтэй, өнгөрсөн нь ээдрээтэй юм. Олон зууны тэртээ түүхийн урт хугацаанд нэгэн урт хэрмийн ар өврөөр зааглагдан оршин амьдарч ирэхдээ Монгол, Хятад хоёр нэг нэгнийхээ дотоод амьдралыг муухан мэддэг, харилцан мэдээлэл тийм ч их биш байдлаар явж ирж дээ гэж боддог.. ЭСЯ-нд ажиллах хугацаандаа “Соёлын хувьсгал” гэгчийн эхлэл, төгсгөлийг үзэж өнгөрүүлсэн. Улаан хамгаалагчид манай ЭСЯ-ыг бүслэн хааж, улмаар дайран орж сүйтгэж байсныг одоо бодоход аймаар ч байсан юм шиг. Гэвч энэ бүхэн өнгөрсөн түүх болон ард үлдсэн, хоёр улсын харилцаанд нөлөөлөх учиргүй. Тэр хувьсгал гэгчийг үүсгэн явуулахад Хятадын ард түмэнд буруу байгаагүй. Харин хүнд хохирол бүхнийг Хятадын ард түмэн л үүрсэн гэж би үздэг.. Ер нь хятад хүмүүсээс сурах нэг гол зүйл бол ямар ч төрлийн ажил байсан хамаагүй, хар бор гэж голохгүйгээр хариуцсан ажлаа хийсэн юм

шиг хийдэгт оршино... Тянь-Аньмэний хэрэг богино хугацаанд ч гэсэн дэлхий нийтийн анхаарлыг татсан их л дуулиантай хэрэг болсон доо. Ямар ч гэсэн эмх замбараагүй байдлыг зогсоож, журам дэглэмд оруулсныг нь зөв гэж би хувьдаа үздэг” зэрэг сонирхолтой бөгөөд санаа авуштай дурсамжийг бидэнд үлдээсэн байдаг. Энэхүү дурсамжийг нь ЭСЯ-наас Монгол, Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойг тохиолдуулан гаргасан “Найрамдал, хамтын ажиллагааны нэгэн жаран” номд тусгайлан оруулсан нь Ч.Далай гуайн Монгол, Хятадын харилцааны хөгжилд оруулсан хувь нэмрийг хойч үедээ тодотгон үлдээх зорилготой байсан билээ.

Ч.Далайн гуайн ЭСЯ-нд ажилласан 2 удаагийн томилолтын 9 жилийн хугацаа нь Хятад улсын түүхийн хувьд ч онц сонирхолтой, Монгол-Хятадын харилцааны хувьд ч онцлог жилүүд таарсан тул түүний бичиж үлдээсэн тэмдэглэл материалыг нарийвчлан судлах нь өнөө үеийн дипломатч, эрдэмтэн судлаачдад өмнөд хөршийг илүү танин ойлгох, хоёр улсын харилцааны түүхэн явцыг ухан ойлгоход тустай болов уу хэмээн бодож байна.

Өнөөдрийн хурлын үеэр Хятадын гадаад, дотоод бодлого, Монгол-Хятадын харилцааны талаар олон чухал сэдвээр хэлэлцүүлэг өрнөх юм байна. Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.